

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны II улирлын тойм мэдээ

МАНАЙ ҮНДСЭН ЗОРИЛГО

Дэлхийд тэргүүлэх, аюулгүй, тогтвортой зэсийн бизнесийг хамтдаа цогцлоож, эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах

МАНАЙ АЛСЫН ХАРАА

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ



• 2026 оны хоёрдугаар улиралд үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 2.2 их наяд төгрөг дотоодод зарцуулжээ. Энэ нь Оюу толгойн үйл ажиллагааны үр өгөөжөөр өдөр бүр 24.4 тэрбум төгрөг Монгол Улсын эдийн засгийн эргэлтэд орсон гэсэн үг юм.

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!




ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ



ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ
ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(мян.тонн)



Зорилт (91 тонн,
хоёрдугаар
улиралд)

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ
ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ

(мян.унц, 1 унц = 31,1 грамм)



Зорилт (97
мянган унц,
хоёрдугаар
улиралд)

- Гүний уурхайн үйлдвэрлэл эрчимжиж, ил уурхай өндөр агуулгатай хүдрийн бүсүүдэд нэвтэрснээр зэс, алтны үйлдвэрлэл өндөр үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд 2026 оны эхний хагас жилийн үйлдвэрлэлийн гүйцэтгэл өндөр байж, оны үлдсэн хугацаанд үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө бүрэн биелүүлэх баттай суурийг бүрдүүллээ.
- Панель 0-ийн олборлолт бүрэн хүчин чадалдаа хүрсэн нь гүний уурхайн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх төлөвлөгөөний чухал алхам боллоо. Үүний зэрэгцээ Панель 2 Хойд (P2N)-ын бүтээн байгуулалт эрчимтэй урагшилж байгаа нь олборлолтын хэмжээ цаашид тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлж байна.
- 2026 оны хоёрдугаар улиралд гүний уурхай, ил уурхай, баяжуулах үйлдвэрийн хэмжээнд хийгдсэн томоохон засвар үйлчилгээ, төлөвлөгөөт зогсолтын ажлуудыг аюул, осолгүйгээр амжилттай хэрэгжүүллээ. Үүнд гүний уурхайн хүдэр өргөх, бутлах, тээвэрлэх системүүд, ил уурхайн ачилтын техникүүд, мөн баяжуулах үйлдвэрийн бутлуурын туузан дамжуурга болон тээрмийн гол тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээ багтав. Эдгээр ажлыг үйлдвэрлэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр гүйцэтгэн, оны хоёрдугаар хагаст үйлдвэрлэлийг тогтвортой, найдвартай үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангалаа.

Баяжуулах үйлдвэрийн
Хүдрийн агуулах

Манай ажлын үзүүлэлт, 2026 оны II улирлын тойм мэдээ



ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2026, II УЛИРАЛ)

834

ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ

ТАТВАР ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ
ТӨЛЖЭЭ.

Татвар, хураамж, үндэсний
компаниудад төлсөн НӨАТ* зэрэг
бусад төлбөрт 17.5 их наяд төгрөг**
2010 оноос хойш төлсөн.

* “Оюу толгой” ХХК НӨАТ-ын буцаан
олголт авдаггүй.
** Энэ дүнд олон улсын арбитрт
хэлэлцэгдэж буй 2.9 их наяд төгрөгийн
татварын маргааны төлбөр багтсан
болно.



**2026 оны хоёрдугаар улиралд 141 түнш
байгууллагын нийт 7,093 ажилтныг сургалтын
хөтөлбөрүүдэд хамруулж, мэдлэг, ур чадварыг нь
дээшлүүллээ. Үүнд:**

- Аюулгүй ажиллагааны сургалт
- Мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт
- Суурин болон хөдөлгөөнт тоног
төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээтэй
холбоотой ажлын байрны нарийн мэргэжлийн
сургалтууд багтсан байна.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2026, II УЛИРАЛ)

2.2

ИХ НАЯД
ТӨГРӨГ

2026 оны хоёрдугаар улиралд дотоодын эдийн
засагт 2.2 их наяд төгрөгийн бодит урсгал бий
болгожээ.

62

ИХ НАЯД
ТӨГРӨГ

(2010-2026, II УЛИРАЛ)

Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт,
бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар,
хураамж, үндсэн ажилчдын цалинд 2010 оноос
хойш 62 их наяд төгрөг зарцууллаа.

71%

Аж ахуй нэгж, бусад
байгууллагад төлсөн төлбөр
(НӨАТ-тай)

22%

Улс, орон нутгийн төсөвт
шууд төлсөн төлбөрүүд

7%

Цалин

ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

(2026, II УЛИРАЛ)

1.3

ИХ НАЯД
ТӨГРӨГ

2010 оноос хойш дотоодын худалдан
авалтад 41.8 их наяд төгрөг зарцуулсан
бөгөөд үүнээс 1.3 их наяд төгрөгийг
2026 оны хоёрдугаар улиралд
зарцуулсан байна. Тайлант хугацаанд
нийт худалдан авалтын зардлын 89
хувийг дотоодын ханган нийлүүлэгчдэд
зарцуулсан бөгөөд нийт 696 ханган
нийлүүлэгчтэй хамтран ажилласны 519
нь дотоодын ханган нийлүүлэгч байв.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2026, II УЛИРАЛ)

321.9

ТЭРБУМ
ТӨГРӨГ


2010 оноос хойш Өмнөговь аймагт
бүртгэлтэй ханган нийлүүлэгчдээс
нийт 6.7 их наяд төгрөгийн бараа,
үйлчилгээ худалдан авсан байна.
Тайлант хугацаанд Өмнөговь аймгийн
102 ханган нийлүүлэгчдээс 320.7
тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээний
худалдан авалт хийсэн байна.

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(2026, II УЛИРАЛ)



Тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 2015 оноос хойш 2026 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 504.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Боловсрол	1.5 тэрбум төгрөг
Түүх соёл	33 сая төгрөг
Эрүүл мэнд, сайн сайхан байдал	1.3 тэрбум төгрөг
Дэд бүтэц	9.1 тэрбум төгрөг
Орон нутгийн бизнесийн хөгжил	3.9 тэрбум төгрөг
Спорт	1.7 тэрбум төгрөг

Манай ажлын үзүүлэлт
2026 оны II улирлын тойм мэдээ



Ханбогд сум гэр бүлд ээлтэй,
бие даан хөгжих чадамж бүхий
суурин болон хөгжиж байна.

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Зорилт
*0.27-аас бага байлгах

Гүйцэтгэл
0.33

2026 оны хоёрдугаар улиралд гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.33 ноогдож байна. Жилийн зорилтот түвшинд хүрэхийн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн хэрэгжүүлж байна.

МОНГОЛ АЖИЛЧДЫН ХУВЬ
Хөрөнгө оруулалтын гэрээгээр
хүлээсэн үүрэг 90%

97.7%

ЭМЭГТЭЙ АЖИЛТАН
24.2%

ОРОН НУТГИЙН АЖИЛЧДЫН
ЭЗЛЭХ ХУВЬ
24.6%

БОЛОВСРОЛ, ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

“Оюу толгой” компани ирээдүйн чадварлаг уурхайчид, инженерүүд, салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хувь нэмрээ тууштай оруулсаар байна.



УЛСЫН ХЭМЖЭЭНД

2010 оноос хойш 2,323 сурагч/оюутан Залуусын хөгжлийн хөтөлбөр, Дотоодын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдлаа.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД

2016 оноос хойш 855 оюутан Говийн оюу оюутны тэтгэлэг, Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хамрагдлаа.



КАРЬЕР ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

2013 оноос хойш 1,617 сурагч/оюутан Шинэ төгсөгчийн хөтөлбөр, Дадлагын болон Дадлагажигч хөтөлбөр, Ажил, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдлаа.

Манай ажлын үзүүлэлт, 2026 оны II улирлын тойм мэдээ



Гүний уурхайн Суурин тоног
төхөөрөмжийн хамт олон, Босоо ам 2



ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2026, II УЛИРАЛ)

7.1
ТЭРБУМ ТӨГРӨГ




“Оюу толгой” компани Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон холбогдох гэрээнүүдийн дагуу ус ашигласны төлбөрийг бүрэн төлж ирсэн бөгөөд 2013 оноос хойш ус ашигласны төлбөрт нийт 233 тэрбум төгрөг төлсөн.

86.7%

2026 оны хоёрдугаар улиралд ус дахин ашиглалтын зорилт 80 хувь байсан бөгөөд зорилтоо давуулан биелүүлж, дунджаар 86.7 хувьд хүргэв.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ


(НЭГ ТОНН ХҮДЭР БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ, ШОО МЕТР, САРААР)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа 2026 оны хоёрдугаар улиралд нөхөн сэлбэлтээр 0.46м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас ойролцоогоор гурав дахин бага ус ашиглаж байна.

ОЮУ ТОЛГОЙ ҮЙЛДВЭРИЙН УС АШИГЛАЛТ

(ЛИТР/СЕКУНД, САРААР)



Оюу толгой үйлдвэр Засгийн газраас тогтоож өгсөн хязгаараас бага ус хэрэглэж байна.



Хаягдал тунгаах сан нь баяжуулах процессоос үлдсэн хаягдлаас усыг ялган хуримтлуулах сан руу илгээж, үлдэгдэл шаварлагийг хаягдлын сан руу илгээнэ. Энэхүү байгууламж нь уурхайн усаа дахин дахин эргэлдүүлэн ашиглах битүү системийн чухал дэд бүтэц юм.



ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

100
САЯ МОД
Өвлүүлэн үлдээе

**ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАРААХ
АЖЛУУДЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭВ:**

- Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгуудад нийт 1,550 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг хэрэгжүүлж, 2.85 сая мод тарьж, нэмэлтээр 600,000 мод тарих ажлыг эхлүүлэв.
- Хариуцлагагүй уул уурхайн улмаас эвдэрч орхигдсон газрын нөхөн сэргээлтийн хүрээнд Сэлэнгэ, Дархан-Уул аймагт нийт 1,630 га талбайд нөхөн сэргээлтийн ажил үргэлжилж байна.
- Архангай аймагт 1.5 сая суулгацын хүчин чадалтай мод үржүүлгийн газрын бүтээн байгуулалтыг эхлүүлж, Өмнөговийн 3 мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг орон нутгийн байгууллагад шилжүүлэв.



Газрын нөхөн сэргээлтийн үр дүнд Ялбагийн хөндийн байгалийн унаган төрх сэргэлээ.

